



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 136, Утас: 7012 8801,
Факс: (976) 32 06 33, И-мэйл: admin@hdc.gov.mn,
Вэбсайт: www.hdc.gov.mn

2023.02.01 № 100

танай _____-ны № _____-т


**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗАР БОЛОН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ**

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2012 оны 427 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу тусгай мэргэжлийн төв болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдээс 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар ирүүлсэн мэдээг нэгтгэн хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 6 хуудас.


Хүндэтгэсэн,

ЗАХИРГАА, САНХҮҮ, УДИРДЛАГЫН
АЛБАНЫ ДАРГА Л.ОЮУНЧИМЭГ



142200000443

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
2023 оны 01 сарын 01 өдрийн
100 дугаар тоотын хавсралт



**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар/

1. Хавдар судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй байна. Эмчийн үзлэг хийлгэхээр нийт 397 үйлчлүүлэгч 2-с дээш хоногоор хүлээж байгаа нь өмнөх оны 12 сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 94% /373/ нь 7 ба түүнээс дээш хоногоор хүлээгдэлтэй байна. /Хүснэгт 1/.

**Хүснэгт 1 . Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн
хүлээгдэл**

№	Үзлэгийн кабинетын нэр	Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо	
		4-6 хоног	7-с дээш хоног
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	1	69
2	Хими	3	60
3	Ерөнхий мэс засал	9	51
4	Толгой, хүзүүний мэс засал	1	48
5	Хөхний төв	1	38
6	Туяа	1	33
7	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	3	28
8	Ангиографи	1	24
9	Элэг судлал	1	17
10	Цээжний хөндийн мэс засал	2	4
11	Ерөнхий хавдар судлал	1	1
	Нийт	24	373

Эмэгтэйчүүдийн мэс засалд үзүүлэхээр 70, Хими эмчилгээний зүлэгт орохоор 63, Ерөнхий мэс засалд үзүүлэхээр 60 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн үзлэгт хамаарч байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 4-с дээш хоногоор нийт 102 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь өмнөх оны 12 сарын үзүүлэлттэй ойролцоо үзүүлэлттэй байна. КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 40, ходоод дурандуулахаар 19, хөхний зураг авахуулахаар 15 үйлчлүүлэгч тус бүр 4-с дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд хамаарна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй, нийт 505 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 2/.

Хүснэгт 2 . Хавдар судлалын үндэсний төвийн орны хүлээгдэл

Эмнэлгийн нэр	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо				
	3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	Нийт
Хавдар судлалын үндэсний төв	36	208	253	8	505

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээж буй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 91% нь 7-30 хоногийн хугацаанд ор хүлээж байна. Тус эмнэлгийн ирсэн тайланд орны хүлээгдлийг тасгаар гаргаагүй болно.

2. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж үйлчилгээ 2023 оны 1 сард харьцангуй хүлээгдэл багатай байлаа. Нийт 19 чиглэлийн үзлэгийн кабинетад үзүүлэхээр 8 хүн 2-с дээш хоног хүлээж байна.

Оношилгооны чиглэлээр тусламж, үйлчилгээнд хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд маш их хүлээгдэлтэй, нийт 1664 үйлчлүүлэгч ор хүлээж байна. /Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Чих, хамар, хоолойн тасаг	3-6 хоног	29
		7-14 хоног	65
		15-30 хоног	210
		1 сараас дээш	528
	Нийт		832
2	Нүдний тасаг	3-6 хоног	9
		7-14 хоног	18
		15-30 хоног	43
		1 сараас дээш	200
	Нийт		270
3	БШГМЗ тасаг	3-6 хоног	9
		7-14 хоног	44
		15-30 хоног	36
		1 сараас дээш	133
	Нийт		222
4	Мэс заслын тасаг	3-6 хоног	38
		7-14хоног	67
		15-30 хоног	74
		1 сараас дээш	2
	Нийт		181
5	Урологийн тасаг	3-6 хоног	25
		7-14хоног	35
		15-30 хоног	20
		1 сараас дээш	0

	Нийт		80
6	Хоол боловсруулах эрхтэн судлал	3-6 хоног	12
		7-14хоног	11
	Нийт		23
7	Дотоод шүүрэл судлал	3-6 хоног	2
		7-14хоног	11
		15-30 хоног	5
		1 сараас дээш	0
	Нийт		18
8	Цусны эмгэг судлал	3-6 хоног	5
		7-14хоног	5
		15-30 хоног	3
		1 сараас дээш	0
	Нийт		13
9	Бөөр судлал	3-6 хоног	5
		7-14хоног	4
		15-30 хоног	1
		1 сараас дээш	0
	Нийт		10
10	Зүрх судас судлал	3-6 хоног	0
		7-14хоног	2
		15-30 хоног	4
		1 сараас дээш	0
	Нийт		6
11	Мэдрэл судлал	3-6 хоног	5
		7-14хоног	1
		15-30 хоног	0
		1 сараас дээш	0
	Нийт		6
12	Уушиг судлал	3-6 хоног	0
		7-14хоног	3
		15-30 хоног	0
		1 сараас дээш	0
	Нийт		3
	БҮГД	3-6 хоног	139
		7-14хоног	266
		15-30 хоног	396
		1 сараас дээш	863
	НИЙТ		1664

Чих хамар хоолойн тасагт хэвтэхээр нийт 832 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь эмнэлгийн хэмжээнд нийт орны хүлээгдлийн тал хувийг эзэлж байгаа ба 832 үйлчлүүлэгчийн талаас илүү буюу 63% нь 1 сар ба түүнээс дээш хугацаагаар хүлээгдэлтэй байна. Нүдний тасагт хэвтэж эмчлүүлэхээр 270 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн дийлэнх буюу 74% /200/ нь 1 сараас дээш хоногоор ор хүлээж байна. Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасагт эмчлүүлэхээр 222 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн 133 /59%/ нь 1 сараас дээш хоногоор хүлээгдэлтэй байгаа юм.

3. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Нийт 145 үйлчлүүлэгч амбулаторийн 8 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс 44 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнээс хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлал, Мэдрэл судлалын эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	3 хоног	5
		4-6 хоног	1
		7-с дээш хоног	56
	Нийт		62
2	Мэдрэл судлал	3 хоног	3
		4-6 хоног	2
		7-с дээш хоног	17
	Нийт		22
3	Мэс засал судлал	3 хоног	7
		4-6 хоног	2
		7-с дээш хоног	12
	Нийт		21
4	Эмэгтэйчүүд судлал	3 хоног	14
		4-6 хоног	1
		7-с дээш хоног	3
	Нийт		18
5	Бөөр судлал	7-с дээш хоног	13
	Нийт		13
6	Нүд судлал	3 хоног	5
	Нийт		5
7	Зүрх судас судлал	4-6 хоног	1
		7-с дээш хоног	2
	Нийт		3
8	Уушиг судлал	4-6 хоног	1
	Нийт		1
	БҮГД	3 хоног	34
		4-6 хоног	8
		7-с дээш хоног	103
НИЙТ		145	

Хүлээгдэлтэй байгаа үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 71% /103/ нь 7-с дээш хоног эмчид үзүүлэхээр хүлээж байна.

Эхо оношилгоо хийлгэхээр хамгийн их буюу нийт 37 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь өмнөх сараас 18 үйлчлүүлэгчээр их, хүлээгдэл нэмэгдсэн үзүүлэлттэй байна. MRI/CT оношлогоо хийлгэхээр 17 үйлчлүүлэгч, рентген зураг авахуулахаар 18 үйлчлүүлэгч 3-аас дээш хоног хүлээж байна. Улсын хоёрдугаар төв эмнэлэгт лабораторийн шинжилгээ хийлгэхээр нийт 20 үйлчлүүлэгч 15-с дээш хоног хүлээж

байгаа нь өмнөх сараас 39 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнээс 14 үйлчлүүлэгч биохимийн шинжилгээ хийлгэхээр хүлээж байна. Орны хүлээгдлийн хувьд авч үзвэл, тус эмнэлгийн орны хүлээгдэл өмнөх сараас 250 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байлаа. Мэс заслын тасаг хамгийн их хүлээгдэлтэй байна. Уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 244 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь өмнөх сараас 123 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна./Хүснэгт 5/.

Хүснэгт 5. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Мэс засал судлал	3-6 хоног	38
		7-14 хоног	122
		15-30 хоног	84
	Нийт		244
2	Чих, хамар, хоолой судлал	3-6 хоног	36
		7-14 хоног	58
		15-30 хоног	52
	Нийт		146
3	Хоол боловсруулах эрхтэн судлал	3-6 хоног	21
		7-14 хоног	39
		15-30 хоног	51
	Нийт		111
4	Уламжлалт анагаах ухааны эмчилгээний тасаг	3-6 хоног	18
		7-14 хоног	36
		Нийт	54
5	Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасаг	3-6 хоног	12
		7-14 хоног	9
		15-30 хоног	13
	Нийт		34
6	Зүрх судасны эмгэг судлал	3-6 хоног	8
		7-14 хоног	12
		Нийт	20
7	Мэдрэл судлал	3-6 хоног	6
		7-14 хоног	9
		Нийт	15
8	Нүд судлал	3-6 хоног	8
		7-14 хоног	5
		Нийт	13
9	Бөөр судлал	3-6 хоног	5
		7-14 хоног	3
		Нийт	8
10	Уушиг судлал	3-6 хоног	4
	Нийт		4
	БҮГД	3-6 хоног	156
		7-14 хоног	293
		15-30 хоног	200
	НИЙТ		649

Чих хамар хоолойн тасагт хэвтэн эмчлүүлэхээр 146, Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт хэвтэхээр 111 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь хүлээгдэл ихтэй тусламж, үйлчилгээнд хамаарч байна.

4. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

Тус төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх оны 12 сараас ихэссэн үзүүлэлттэй байна. Эмгэг сэтгэл судлалын үзлэгт хамрагдахаар 28 үйлчлүүлэгч 3-6 хоног, 28 үйлчлүүлэгч 7-14 хоног тус тус хүлээж байна. Харин стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 51 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байгаа нь өмнөх жилийн 12 сарын үзүүлэлтээс 59 үйлчлүүлэгчээр буурсан байна.

5. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 43 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байна./ Хүснэгт 6/

Хүснэгт 6. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	3 хоног	21
2	4-6 хоног	12
3	7-с дээш хоног	10
	Нийт	43

Тус эмнэлэгт MRI оношилгоо хийлгэхээр 426 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх жилийн 12 сарын хүлээгдлээс даруй 237 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. MRI шинжилгээ хийлгэхээр хүлээж байгаа үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 87% / 333/ нь 15-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Хэвтүүлэн эмчлэх үйлчилгээнд хүлээгдэл бүртгэгдээгүй байна.

6. Геронтологийн үндэсний төв нь 2023 оны 1 дүгээр сард хүлээгдэлгүй ажиллаж байна.
7. ШУГТЭ, АӨСҮТ, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, амаржих газрууд, Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.